

## Улын Их Хурлын 2015 оны Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн эхний хагас жилийн хэрэгжилт

ХӨТӨЛБӨР: Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих

2015.08.05

Код	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
2	<p>2.1 Хууль, тогтоолын төсөл хэлэлцэж батлах</p> <p>2.2 Хууль, тогтоолын биелэлтийг хянан шалгах, холбогдох тайлан, мэдээллийг хэлэлцэх, сонсох</p>	<p>100-аас доошгүй ажлын өдөр хуралдаж хууль, тогтоолын төсөл хэлэлцэж батлах</p> <p>10-аас доошгүй удаа хяналт шалгалт хийх, 6-аас доошгүй удаа тайлан хэлэлцэх, 12-оос доошгүй удаа мэдээлэл сонсох</p>	<p>Улсын Их Хурлын чуулган Улсын Их Хурлын тухай хуулийн 15.1-т заасан заасан хугацаанд хуралдаж /105 хоног/ бие даасан хууль 18, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 125, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 24, зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль 11, Улсын Их Хурлын тогтоол 66 -ыг тус тус батлав.</p> <p>Хяналт шалгалтын чиглэлээр 14 ажлын хэсэг байгуулагдан давхардсан тоогоор 51 яам, агентлагын үйл ажиллагаанд шалгалт явуулж хууль тогтоолын хэрэгжилттэй тайлцав. УИХ-д ажлаа шүүд хариуцан тайлагнадаг 10 байгууллагын үйл ажиллагааны тайланг холбогдох байнгын хороодоор хэлэлцэж тодорхой зөвлөмж чиглэл өгөв. Давхардсан тоогоор УИХ-ын 25 гишүүн 48 асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Монголбанкны Ерөнхийлөгчид хандан 14 удаа асуулга тавьж УИХ-ын нэгдсэн хуралдаанаар сонсох ажлыг зохион байгууллаа. Хуралдаанд УИХ-ын 31 гишүүн 67 аман асуулт тавьж, асуулга тавьсан гишүүд санал бодлоо илэрхийлэв. Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 удаагийн сонсох давхардсан тоогоор 29 гишүүн 84 асуулт тавьж, хариулт авав. Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Засгийн газарт болон Засгийн газрын гишүүдэд 83 хуулийн 293 заалтаар үүрэг өгснөөс давхардсан тоогоор 120 заалт хэрэгжиж, 28 заалт хэрэгжих шатанд, 145 заалт хэрэгжээгүй байна.</p> <p>Улсын Их Хурлын 59 тогтоолын 208 заалтыг хяналтад авч ажиллав.</p>	100
2.3	Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах	Хуульд заасны дагуу хангагдсан байх	49 хууль, 53 тогтоолын эцсийн найруулгыг бэлтгэж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэв. Хууль санаачлагчийн УИХ-д өргөн мэдүүлсэн нийт 95 хууль, 12 тогтоолын бүрдлийг хянав. 9 хууль, 6 тогтоолыг хуульд заасан шаардлагыг хангуулахаар хууль санаачлагчид нь буцаав. Байнгын хороодын хуралдаанаар давхардсан тоогоор 358 хууль, 75 тогтоолын төслийг хэлэлцүүлэв. Байнгын хорооны 46 танилцуулга бэлтгэж, 1551 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулав	100

	<p>100</p> <p>Чуулганы 47 удаагийн нэгдсэн хуралдааны 238 цаг 06 минутын бичлэгийг дууны бичлэгээс буулган, 663 хуудас гар тэмдэглэл, 4200 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл, 3588 хуудас холбогдох баримт бичгийн хамт нийт 8471 хуудас материал болон байнгын хороодын 165 удаагийн хуралдааны 275 цаг 22 минутын бичлэгийг дууны бичлэгээс буулгаж, 867 хуудас гар тэмдэглэл, 4801 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл, 5668 хуудас материал бэлтгэв.</p> <p>Баталсан хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах чиглэлээр 91 удаа уулзалт, ярилцлага, хэвлэлийн бага хурал зохион байгуулав. Дотоод сүлжээ болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a> цахим хуудаст шинээр 155 хууль, 63 тогтоолыг файлаар оруулан өөрчлөлт хөдөлгөөнийг хийж, Тамгын газрын хууль тогтоомжийн санд Ерөнхийлөгчийн 42 зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 252 тогтоол, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 12 шийдвэрийг шинээр нэмэн оруулж, "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 23 дугаарыг хэвлэн түгээв.</p> <p>Монгол Улсын Их Хурал, Монголын Парламентын бүлгэм, Улсын Их Хурлын Тамгын газрын гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэн гадаад, дотоодын 14 айлчлал, арга хэмжээг хэрэгжүүлэв.</p> <p>Тамгын газар нь Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн төсөв, санхүү, аж ахуй, техник хэрэгсэл, материал хангамжийн үйлчилгээг цаг тухайд нь шуурхай үзүүлж үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлсэн болно.</p>
--	--

Ерөнхий нарийн бичгийн дарга

Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга



Б.Болдбаатар

Н.Ширэндэв